



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 4/55

Модот

Нүүлгэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоол, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 32 дугаар зүйлийн 32.1.4, 32.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Соёлын төвийн барилгын дээврээс борооны ус ихээр гоожсоны улмаас цаашид тус барилгад үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тул нүүлгэн шилжүүлсүгэй.

2. Соёлын төвийн барилга доторх архивын баримт бичиг, номын сан болон бусад эд хөрөнгийг тус сумын жижиг дунд үйлдвэрийн байранд нүүлгэн шилжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч С.Энхбаяр	- Байгаль орчны хяналтын байцаагч
Нарийн бичгийн дарга Э.Навчаа	- Соёлын төвийн дарга
Гишүүд Л.Энхнас	- Номын санч
Г.Нарангарав	- Соёлын төвийн өвийн ажилтан
Б.Буяндэлгэр	- Санхүү албаны нягтлан бодогч

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЗОЛЖАРГАЛ

